



ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ ТӨСӨВЛӨЛТ ДОРНОД АЙМАГТ

Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах (MERIT) төсөлд тайлагнав.

2021 оны 10 дугаар сар



Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах (MERIT) төсөл нь 8 жилийн хугацаатай (2016-2024), Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж байна.

MERIT нь олборлох салбарын менежментийн тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилготой засаглал бэхжүүлэх төсөл юм. Засаглалыг бэхжүүлж, хүртээмжтэй эдийн засаг, нийгмийн хөгжлийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

АЛСЫН ХАРАА

Төрийн байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх замаар Монголын ард түмний амьдралын чанарыг сайжруулах тэгш хүртээмжтэй, тогтвортой нийгэм-эдийн засгийн хөгжлийг бий болгоход хувь нэмрээ оруулах явдал юм.

- 📍 Монгол Улс,
Улаанбаатар-15160,
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Худалдааны гудамж, Нэйшнл
Таймс Ньюс Тауэр, 3-р давхар
- ✉ support@merit.mn
- 🌐 www.merit.mn
- ☎ +976 7610-5000
- 📱 @merit.mn

ТАЛАРХАЛ

MERIT төслийн захиалгаар Канад Улсын Intelligence Publique компани нь Монгол улсын Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг орон нутгийн түвшинд нэвтрүүлэх жишиг төслийг боловсруулан, сургалт зохион байгуулж, үнэлгээ хийхэд зөвлөн тусалж ажиллаа. Уг жишиг төсөл нь Үндэсний зөвлөн Доктор, профессор Л.Отгонтуяагийн оролцоо, дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжсэн болно.

Түүнчлэн энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлэхэд манлайлан чиглүүлсэн Дорнод аймгийн Засаг дарга болон идэвхтэй оролцсон тус аймгийн төрийн албан хаагчдад гүн талархал илэрхийлье.

Сангийн яам, Жендэрийн Үндэсний хороо (ЖҮХ), Дэлхийн банк, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ)-тэй тогтмол хамтран ажиллаж, туршлагаасаа хуваалцаж, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулахыг зорьлоо.

Энэ удаагийн жишиг төсөл нь нийгэмд эерэг өөрчлөлт авчрах хүсэлтэй олон хүмүүсийн дэмжлэгтэйгээр хэрэгжлээ.

АГУУЛГА

ХУРААНГУЙ	4
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН	6
ҮЙЛ ЯВЦ	8
Төлөвлөсөн үйл явц	9
Үйл явцын бодит хэрэгжилт	9
Хичээл зүтгэл	11
ҮР ДҮН	12
Ерөнхий үр дүн	12
Оролцогчдын статистик	12
Оролцогчдын сэтгэл ханамж	14
Бүрэн хэрэгжсэн бичил төслүүд	16
Номын сан загвар бичил төсөл	16
Бүрэн хэрэгжихэд ойрхон байгаа бичил төсөл	17
Төлөвлөөгүй үр дүн	17
АГУУЛГА	18
СУРГАМЖ	19
Алгуур аргачлал	19
Зөвлөх, сургагч багш нарын чадамж	19
Байнгын эргэх холбоо	20
Удирдлагын дэмжлэг	20
Албан хаагчдын манлайлал	20
Орчуулгын чанар	20
ТӨСЛИЙН БАГТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ	21
БОДЛОГО ТОДОРХОЙЛОГЧ НАРТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ	23
ХАВСРАЛТУУД	24
Зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээний жагсаалт	25
Уриалга	26
Багийн бүрэлдэхүүний хүйсээр ангилсан мэдээлэл	27
ЖМТ жишиг төслийн үйл ажиллагааны зургийн цомгоос	28
Intelligence Publique	29



ХУРААНГУЙ

Монгол улсын Дорнод аймаг болон Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй MERIT төсөл хамтран Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг орон нутгийн захиргааны байгууллагад нэвтрүүлэх жишгийг бий болгох дэд төслийг 2020 оны 7-р сараас 2021 оны 7-р сарын хооронд хэрэгжүүллээ. Дорнод аймгийн 73 төрийн албан хаагч, 7 зочин оролцогчоос бүрдсэн нийт 80 оролцогч чадавхжуулах сургалт, зөвлөх үйлчилгээнд хамрагдаж өөрсдийн эрхлэх ажлын хүрээнд жендэрийн зөрүүтэй байдлыг арилгах, хариу арга хэмжээ авах чиглэлээр суралцлаа.

Жишиг төслийн зорилго:

- Орон нутгийн удирдлагын дэмжлэгтэйгээр төрийн албан хаагчид аймаг, сум, багийн түвшний төсвийн зарлагад хүйсээр ангилсан дүн шинжилгээг хийж, хэрэгжилтийг нягтлах.
- Богино хугацаанд хэрэгжих боломжтой төслийн зөрүүтэй байдлыг шинжилж, арилгах хариу арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх.
- Төсөл хэрэгжилтийн явцад тулгарч буй бэрхшээлд дүн шинжилгээ хийж, орон нутгийн захиргаа, төрийн албан хаагчдын зүгээс авч хэрэгжүүлж болохуйц шийдлийг тодорхойлох.


Дээрх зорилгын хүрээнд, **жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт нь эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, охид, хөвгүүдэд улсын төсөв хэрхэн ялгаатай нөлөөлж буйд дүн шинжилгээ хийх, төсвийн баримт бичиг, төсвийн үе шат бүрд жендэрийн өнцгийг тусгаж, нэгдмэл систем болгосноор** жендэрийн тэгш байдлыг хангахад түлхэц үзүүлдэг.

MERIT төсөл нь орон нутгийн түвшинд хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааны төсвийн зарлагад хүйсээр ангилсан дүн шинжилгээ хийх тал дээр төвлөрч ажиллалаа.

Энэхүү ажил нь Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллага, агентлагийн жендэрийн стратеги (2016-2024) зэрэг хууль тогтоомж түүнчлэн, олон улсын шилдэг туршлагад нийцсэн. Энэ нотолгоонд суурилсан жишиг төслийг Монгол улсын нөхцөл байдалд үндэслэн боловсруулсан болно.

COVID-19 цар тахлаас шалтгаалж зарим үйл ажиллагаанд өөрчлөлт оруулсан ч үндсэн үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлсэн.

Сургалтад оролцогчид, хүйсээр



Сургалтын нийт оролцогчдын 80% нь эмэгтэйчүүд байв.

Жишиг төслийн хэрэгжилтийн хугацаанд долоон дэд төсөл амжилттай хэрэгжиж, зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ 100 хувь, гурван дэд төслийн хувьд зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ нь аймгийн жендэрийн дэд хөтөлбөрийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан, нэг дэд төсөл олон улсын ТББ -аас санхүүжилт авсан байна.

Энэхүү жишиг төсөл нь амжилттай хэрэгжсэний зэрэгцээ Монгол Улсын хэмжээнд бусад аймаг, төрийн байгууллагууд хэрэгжүүлэх боломжтойгоороо онцлог юм.



ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН

Энэхүү жишиг төслийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын холбогдох хууль, журам, бодлогод нийцүүлсэн. Тухайлбал,

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах туай хууль (ЖЭТБХТХ), Засгийн газрын 2013 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан уг хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын дунд хугацааны стратеги
2. Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)
3. Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах байгууллага, агентлагийн жендэрийн стратеги (2016-2024)

ЖЭТБХТХ нь 2011 онд батлагдсанаар салбар хороо, зөвлөлүүдийн чадавхыг бэхжүүлэхэд голлон анхаарч иржээ. Засгийн газрын дунд хугацааны стратегийн хэрэгжилтэд Жендэрийн Үндэсний Хороо (ЖҮХ)-ны ажлын алба 2016 онд гүйцэтгэлийн үнэлгээ хийсний дараа жендэрийн эрх тэгш байдлын тухай ойлголтыг бүх салбар, орон нутаг, байгууллагын түвшинд нэвтрүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг бүх шатанд эрчимжүүлэх, жендэрийн статистик, дүн шинжилгээг бий болгох зорилгоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийг боловсруулж, батлуулсан.

ЖЭТБХТХ, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт жендэрийн

мэдрэмжтэй бодлогыг төлөвлөж, хэрэгжүүлэх замаар жендэрийн эрх тэгш байдлыг тогтоож хадгалахад үндэсний, салбарын, орон нутгийн захиргааны байгууллагууд болох УИХ, Засгийн газар, Ерөнхий сайд, ЖҮХ, төрийн захиргааны төв байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага зэрэг байгууллагуудын хүлээх үүргийг мөн тодорхой заасан байдаг.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн талаар ЖЭТБХТХ-ийн 16.1.1-д улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөр, тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх, эдгээрийн хэрэгжилтийг хангахуйц санхүүгийн эх үүсвэрийг батлуулахыг Засгийн газрын бүрэн эрх болгож заасан.

ЖЭТБХТХ болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн дагуу яамд, нийслэл, 21 аймаг салбарын болон орон нутгийн жендэрийн бодлогыг (жендэрийн дэд хөтөлбөр) баталж хэрэгжүүлж байна. Эдгээр бодлогын баримт бичиг бүрт бодлогод жендэрийн дүн шинжилгээ хийх, жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт-шинжилгээ, үнэлгээнд тусгах, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг тусдаа зорилт, эсвэл бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг санхүүжүүлэх арга зам байдлаар оруулжээ.

Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллага, агентлагуудад хэрэгжих жендэрийн стратеги (2016-2024)-ийн тэргүүлэх зорилт 3-т “Сангийн сайдын болон зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн үйл явцыг үе шаттайгаар жендэрийн мэдрэмжтэй болгоно” гэж тодорхойлсон байна.

Тус зорилтын дагуу Сангийн яам нь төлөвлөлт, төсөвлөлт хариуцсан төрийн албан хаагчдыг чадавхжуулж, дэмжлэг үзүүлэх, жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлал боловсруулах үүрэг, хариуцлагыг хүлээж байна.

Үүнтэй адил зорилт, үйл ажиллагаа бусад салбарын жендэрийн талаар баримтлах бодлогод ч мөн тусгагджээ. Тухайлбал, Хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар (зорилт 1.3), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар (зорилт 1.2), Байгаль орчин, аялал жуулчлалын салбар (зорилт 1.1 болон 2.1), Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар (зорилт 1.3) болон Геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбар (зорилт 1.2)-ын жендэрийн талаар баримтлах бодлогод тус тус тусгагдсан байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021)-ийн 2.2.2-т “жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсвийг үндэсний, салбарын, орон нутгийн байгууллагын түвшинд хэрэгжүүлэх” зорилтыг дэвшүүлсэн юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/132 тоот тушаалаар “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталсан бөгөөд уг төлөвлөгөөний 2.13-т “Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд жендэрийн дүн шинжилгээ хийж, төсвийг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх, үнэлэх аргачлал боловсруулах” үйл ажиллагааг Сангийн яам, ТББ, ОУБ-ын оролцоотойгоор хэрэгжүүлнэ гэж заажээ.

Эдгээр бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, төрийн хүчин чармайлтыг ажил хэрэг болгох үүднээс Жендэрийн Үндэсний Хороо нь Монгол Улсад жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн аргачлалыг бий болгохын төлөө ажиллаж байгаа бөгөөд НҮБ-ын Хүн амын сан, Дэлхийн банк, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, MERIT төсөл зэрэг донор байгууллагуудтай хамтран Монголын нөхцөл байдалд тохирсон аргачлалыг боловсруулахаар ажиллаж байна.

Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ) аргачлалыг Монгол Улсад нэвтрүүлэхийн тулд Европын Холбооны санхүүжилтээр Дэлхийн Банкны хэрэгжүүлж буй “Монгол Улсад засаглалыг бэхжүүлэх” төсөл нь ЖМТ-ийн аргачлалыг боловсруулах, турших, хэрэгжүүлэх ажлыг 2019 оноос эхлүүлсэн. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн төлөвлөлтийг нэвтрүүлэх хуулийн санаачлага нь одоогоор эхний шатандаа явж байна.



ҮЙЛ ЯВЦ

Жишиг төсөл нь шинэ мэдлэг олгох, оролцогчдын мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх, цаашлаад шинэ зан төлөв, дадлыг суулгахад чиглэсэн оролцоонд суурилсан үндсэн гурван бүрэлдэхүүн хэсгээс бүрдсэн. Үүнд:

- Оролцогчид баг бүрдүүлж, бодит кэйс дээр тулгуурласан хэрэгжих боломжтой зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ (бичил төсөл) загварчлан боловсруулах 5 өдрийн сургалт.
- Бичил төслийг хэрэгжүүлэх явцад багын гишүүдийг (өмнөх 5 өдрийн сургалтын үеэр бүрдсэн) зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ авах, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх чиглэлээр дадлагажуулах (коучинг).
- Мэдлэг бататгах сургалтаар оролцогчид зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ буюу бичил төсөл хэрэгжүүлсэн туршлага, сургамжаа бусад багийнхантайгаа хуваалцах, хэрэгжилт сул байгаа багууд бусдаасаа суралцах, урам авах боломжийг олгосон. Энэхүү сургалт нь оролцогчдын идэвх оролцоог нэмэгдүүлсэн.

Дээрх төлөвлөсөн үйл ажиллагаанууд нь амжилттай хэрэгжснээр оролцогчид сурсан мэдлэг, аргачлалыг эзэмшиж, ашиглах чадвартай болсон.

ТӨЛӨВЛӨСӨН ҮЙЛ ЯВЦ

Жишиг төслийг боловсруулахдаа сургалт, уулзалтуудыг танхимаар хүргэхээр төлөвлөсөн. Канад зөвлөх нь төлөвлөсөн хуваарийн дагуу Монголд ирж үндэсний зөвлөх, MERIT төслийн баг, үр шим хүртэгчид буюу сургалтад оролцогчидтой хамтран ажиллахаар дараах долоон үндсэн үйл ажиллагааг төлөвлөж байв. Үүнд:

1. Аймаг, сум, багийн төрийн албан хаагчдад зориулсан “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” сэдэвт чадавх бэхжүүлэх сургалт (хөтөлбөрийн төлөвлөлт, жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт, нийтэд хүртээмжтэй бодлогын талаар).
2. Зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээг боловсруулах, хэрэгжилтийг хангах талаар дээрх албан хаагчдыг дадлагажуулах (коучинг).
3. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сэдэвт төрийн албан хаагчдад зориулсан мэдлэг бататгах сургалт.
4. Зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ буюу бичил төслийг сурталчлах, танилцуулга хийх чиглэлээр дадлагажуулах (коучинг).
5. Төслийн менежмент сэдэвт чадавхжуулах сургалт.
6. Хяналт шинжилгээ, үнэлгээ сэдэвт чадавхжуулах сургалт.
7. Асуудал, зөрчилдөөнийг шийдвэрлэх талаар зөвлөн туслах.

Жишиг төслийг нэг жилийн хугацаанд хэрэгжүүлж, 80 хоног зарцуулахаар төлөвлөсөн.

ҮЙЛ ЯВЦЫН БОДИТ ХЭРЭГЖИЛТ

COVID-19 цар тахлаас шалтгаалж анхны төлөвлөгөөг өөрчилсөн. 2020 оны 1-р сараас эхлэн танхимын сургалт зохион байгуулах, нүүр тулсан уулзалт хийх боломжгүй болсон тул жишиг төслөө хэрэгжүүлэхийн тулд Канад зөвлөх цахимаар, үндэсний зөвлөх болон MERIT төслийн баг газар дээр нь оролцогчтой хамт байж сургалтыг хосолмол байдлаар зохион байгуулсан.

Сургалтын хэлбэрийг шинэчлэн, Канад зөвлөхийн чиглүүлэг дор MERIT төслийн баг танхим дах сургалтыг удирдан явуулсан.

Доорх гурван үйл ажиллагааг хэлбэр, хугацааны хувьд өөрчлөн зохион байгуулсан:

- 1) Аймаг, сумын төрийн албан хаагчдад жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сэдвээр 5 өдрийн сургалтыг 2020 оны 7, 8 дугаар сард зохион байгуулсан. Энэхүү 35 цагийн сургалтын 60 хувьд нь төрийн албан хаагчид багаар ажиллаж, оролцоонд суурилсан байдлаар арга, аргачлалыг эзэмшиж, ашиглах боломжийг бүрдүүллээ.

- 2) Дээрх 5 өдрийн сургалтын үеэр боловсруулсан зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ буюу бичил төслөө хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх 2 цагийн дадлагажуулах сургалт (коучинг)-ыг 2020 оны 9-11 сард баг тус бүрт цахимаар хүргэсэн. Оролцогч төвтэй энэхүү дадлагажуулалтын үеэр багийн гишүүд зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээний явц, туршлагаасаа хуваалцаж, Канад зөвлөх, үндэсний зөвлөх, MERIT төслийн багаас асуулт асууж, харилцан ярилцсан.
- 3) Төрийн албан хаагчдийн нийгэм, байгууллага дах жэндэрийн дүн шинжилгээний талаарх ойлголт, ур чадварыг тэлэх 2 хагас өдрийн мэдлэг бататгах сургалтыг 2021 оны 6-р сард цахимаар зохион байгуулсан. Нийгэм дэх зөрүүтэй байдал, зөрүүг

арилгахад чиглэгдсэн төрийн бодлогууд, оролцоонд суурилсан жэндэрийн аудит, байгууллагын дотоод журмыг сайжруулан охид, эмэгтэйчүүдийг дэмжих арга замыг 12 цагийн цахим сургалтаар танилцууллаа.

Төлөвлөгөөнд тусгагдаагүй дараах үйл ажиллагааг нэмэлтээр зохион байгууллаа.

Дорнод аймгийн ЗДТГ -ын Нийгмийн бодлогын хэлтсийн шинээр томилогдсон даргад багуудын ажлыг танилцуулах уулзалтыг 2021 оны 2 дугаар сард зохион байгуулсан. Энэ нь шинэ томилогдсон даргын жэндэрийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчдын хэрэгжүүлж буй бичил төслүүд буюу зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээний явцаа танилцуулах, багууд бичил төслөө амжилттай хэрэгжүүлэхэд түлхэц үзүүлэх боломж болсон.

Үйл явцыг бүхлээр нь харвал:



MERIT төслийн баг, үндэсний зөвлөхтэй зөвшилцсөний үндсэн дээр төлөвлөгөөнөөс дараах гурван үйл ажиллагааг хассан.

- Төслийн менежмент сэдэвт чадавхжуулах сургалт;
- Хяналт шинжилгээ, үнэлгээ сэдэвт чадавхжуулах сургалт;
- Асуудал, зөрчилдөөнийг шийдвэрлэх чиглэлийн зөвлөх үйлчилгээ.

ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ


Жишиг төслийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах үйл ажиллагаа шаардагдлаа:

- Төлөвлөх;
- Сургалтын материал бэлтгэх (судалгаа хийх, баримт бичиг, кэйс, хичээлийн танилцуулга боловсруулж, бэлтгэх);
- MERIT төслийн баг, Канад болон үндэсний зөвлөхүүдийн хамтыг ажиллагааг зохицуулах;
- Баг бүрийн гишүүдийг дадлагажуулах (коучинг хийх);

- Тохирох оролцогчдыг сонгохын тулд байгууллагуудтай хамтран ажиллах;
- Оролцогчдод сургалт, уулзалтын зар хүргэх;
- Зохион байгуулалтын асуудал: интернэт, цахим уулзалтын платформын бэлэн байдал;
- Аман болон бичгийн орчуулга;
- Явцын болон дунд хугацааны тайлан;
- Зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ буюу бичил төслөө амжилттай хэрэгжүүлэхэд нь оролцогчдыг сэдэлжүүлэх;
- Удирдлагын багтай нягт хамтран ажиллах;
- Жишиг төслийн хамрах хүрээг чиглүүлэх.

Нийт зарцуулсан цагийг ойролцоогоор тооцоход:

- Олон улсын зөвлөх - **355 цаг**
- Үндэсний зөвлөх - **355 цаг**
- MERIT төслийн баг - **1,787 цаг**
- Дорнод аймгийн ЗДТГ - **37 цаг**
- Нэг оролцогч - **110 цаг**





ҮР ДҮН

ЕРӨНХИЙ ҮР ДҮН

Дорнод аймгийн 73 төрийн албан хаагч, 7 зочин оролцогчоос бүрдсэн нийт 80 оролцогчдыг жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн 2 шатны сургалтанд хамруулсан. Тухайлбал 2020 оны 7, 8-р сард оролцогчдыг 3 бүлэгт хуваарилж 5 өдрийн цахим болон танхим (оролцогчид болон MERIT төслийн баг нийтээрээ танхимд, Канад зөвлөх цахимаар холбогдсон) хосолсон сургалт; 2021 оны 6-р сард 4 бүлэгт хуваарилж 2 өдрийн цахим сургалтад тус тус хамруулсан.

Сургалтын үеэр төрийн албан хаагчид хамгийн багадаа нэг удаа өөрийн байгууллагын хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслийн төсвийн зарлагын хүйсээр ангилсан дүн шинжилгээг хийсэн. Тэд багаар ажиллан дээрх төсвийн зарлагын дүн шинжилгээний үр дүнд тодорхойлон гаргаж ирсэн зөрүүтэй


байдлыг бууруулахад чиглэгдсэн хариу арга хэмжээг боловсруулсан. Гурван удаагийн сургалтын үеэр нийт 36 хариу арга хэмжээг боловсруулсан.

Сургалтын явцад багуудын боловсруулсан зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж 31 удаагийн дадлагажуулах (коучинг) үйлчилгээ үзүүлсэн. Энэ үеэр багуудын боловсруулсан 36 зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ буюу бичил төсөлд өөрчлөлт оруулан, 26-г нь хэрэгжүүлэхээр болов. Ихэнх баг зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргасан.


Одоогийн байдлаар, долоон зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ бүрэн хэрэгжиж охид, эмэгтэйчүүдэд үйлчилгээгээ хүргэж байна.

ОРОЛЦОГЧДЫН СТАТИСТИК


2020 оны 7, 8-р сард болсон 5 өдрийн сургалтад хамрагдсан нийт оролцогчдын 76 % нь эмэгтэйчүүд байв.




2021 оны 6-р сард зохиогдсон мэдлэг бататгах сургалтад хамрагдсан оролцогчдын 81 % нь мөн эмэгтэйчүүд байлаа.




Доорх графикт 2020 оны 7, 8-р сард зохион байгуулсан 5 өдрийн сургалтанд хамрагдсан оролцогчдыг аймаг, сумын ЗДТГ, агентлаг болон бусад байгууллагын төлөөлөлөөр нь ангилан харууллаа.




2021 оны 6 сард явагдсан мэдлэг бататгах сургалтанд аймаг, сумын ЗДТГ, агентлагаас хамрагдсан оролцогчдыг хувиар харуулбал:



2020 оны 7, 8-р сард болсон 5 өдрийн сургалтад хамрагдсан оролцогчдыг албан тушаалаар ангилан доорх графикт харуулав.



2021 оны 6-р сард болсон мэдлэг бататгах сургалтад хамрагдсан оролцогчдыг албан тушаалаар ангилан доорх графикт үзүүлэв.



ОРОЛЦОГЧДЫН СЭТГЭЛ ХАНАМЖ


Сургалтад хамрагдсан оролцогчдын сэтгэл ханамж өндөр байгаа нь сургалтын үнэ цэнийг илтгэнэ. Доорх гурван график нь 5 өдрийн сургалт, коучинг уулзалт, мэдлэг бататгах сургалтад оролцогчид сэтгэл ханамж өндөр байгааг илэрхийлж байна.

Үйл ажиллагаа бүрийн дараа үнэлгээний хуудас бөглүүлж оролцогчдыг сургалтын талаарх санал, сэтгэгдэлээ бичих боломжоор хангадаг ба тэд сургалтад сэтгэл хангалуун

байгаагаа илэрхийлжээ. Тухайлбал:

5 өдрийн сургалтад оролцогчдын 92% нь сургалтыг хэрэгжүүлж болохоор буюу өдөр тутмын ажилдаа ашиглах боломжтой гэж хэлжээ; 67% нь сургалтыг маш сайн, 25% нь сургалтыг сайн гэж үнэлжээ. Нийт оролцогчдын 87% нь сургалтаас сурсан мэдлэгээ сайн, маш сайн гэж тодорхойлсон байна.

5 өдрийн сургалтад оролцогчдын үнэлгээ




“Сургалт сайхан боллоо, сургалтын агуулга маш ойлгомжтой байсан учраас бичил төслөө боловсруулахад хялбар байлаа”.

Сургалтын оролцогч

Мөн түүнчлэн, дадлагажуулах уулзалтын (коучинг) хувьд ч оролцогчид сургалтын агуулгыг сайн, маш сайн түвшинд эзэмшсэн гэж дүгнэсэн.

Мэдлэг бататгах сургалтын үнэлгээ



Мэдлэг бататгах сургалтын оролцогчдын сэтгэгдэлээс:

“Нийгэм дэх жендэрийн зөрүүтэй байдлыг арилгах талаарх хэлэлцүүлгээс олон, олон санааг олж авсан. Хамгийн гол нь зөрүүтэй байдлыг арилгахын тулд бүх салбарт ажиллаж буй төрийн албан хаагчид мэдээлэл, судалгаа, дүн шинжилгээнд илүү анхаарч, жендэрийн сургалтыг түгээж ажиллах хэрэгтэй.”

“Мэдлэг бататгах сургалтын оролцогчдын хандлагад эерэг өөрчлөлт гарсан байгаа нь ажиглагдлаа. Тиймээс, эдгээр оролцогчдоо цаашид идэвхжүүлэх, бусдад нөлөөлөх байдлыг нь байнга дэмжих хэрэгтэй.”

НОМЫН САНГИЙН БИЧИЛ ТӨСӨЛ:

Энэ бол үлгэр жишээ болохуйц зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ юм.

Дорнод аймгийн төв номын сангийн хэрэгжүүлж буй “явуулын номын сан” зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ нь бүрэн хэрэгжсэн төслүүдийн нэг биш боловч, хэрэгжих магадлал маш өндөртэй, үлгэр жишээ зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээний нэг юм.

Дүн шинжилгээ: Дорнод аймгийн төв номын сангийн эрэгтэй, эмэгтэй үйлчлүүлэгчдийн судалгааг хийснээр хөдөө орон нутгаас маш цөөн тооны эмэгтэйчүүд ирж үйлчлүүлснийг номын сангийн дарга олж мэдсэн. Энэ нь соёл урлаг, техник, технологи, мэдлэг олж авах боломж эмэгтэйчүүдэд хязгаарлагдмал байж болзошгүйг илтгэж байлаа. Баг нөхцөл байдлыг ойлгохын тулд шалтгааныг судалсан. Шалтгааны хувьд зарим нь уламжлал, соёлоос үүдэлтэй бол зарим нь хангамжтай холбоотой буюу унаа тээврийн асуудлаас шалтгаалж байлаа.

Зөрүүтэй байдлыг багасгаж, хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүдэд соёл урлаг, техник, технологи, мэдлэг олж авах боломж бий болгох, тэднийг тасралтгүй чадавхжуулахын тулд гэртээ байгаа эмэгтэйчүүд тодорхой хуваарийн дагуу ном авч уншиж болох хөдөөгүүр тойрч явдаг “явуулын номын сан”-тай болох бичил төслийг боловсруулжээ.

Тээврийн хэрэгслийн зохих санхүүжилтийг олох шаардлага байгаа ч энэхүү бичил төсөл нь төвөгтэй асуудалд энгийн шийдэл олсон сайн жишээний нэг юм.

БҮРЭН ХЭРЭГЖСЭН БИЧИЛ ТӨСЛҮҮД

Сургалтын төгсгөлд нилээдгүй үр дүн гарч байна. Жишиг төсөл бодит үр дүнд хүрч, амжилттай хэрэгжсэнийг хариу арга хэмжээний тоогоор илэрхийлж болно. Нийт 26 хариу арга хэмжээнээс долоо нь бүрэн хэрэгжсэн бөгөөд найм нь хэрэгжилтийн сүүлийн шатандаа байна.

Эдгээрийг нэрлэвэл:

1. Малжуулах хөтөлбөрт эмэгтэй малчдын оролцоог нэмэгдүүлэх
2. Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр - “Цэвэр цэмцгэр Чойбалсан хот” төсөл
3. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог дэмжин ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг хөгжүүлэх
4. Хяналт, үнэлгээний олон нийтийн зөвлөлд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
5. Төрийн албан хаагчдын мэргэшүүлэх сургалт (Дорнод аймгийн нийт 4,000 гаруй албан хаагчдийг мэргэшүүлэх сургалтад хамруулах үүрэгтэй Төрийн албаны салбарын зөвлөлтэй хамтарсан “сургагч багш” бэлтгэх сургалтыг оруулаад)
6. Залуучуудын гарааны бизнесийг дэмжих СТАРТ АП хөтөлбөрт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
7. “Старт-Ап”бизнесийг дэмжих туршлага судлах арга хэмжээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх.

БҮРЭН ХЭРЭГЖИХЭД ОЙРХОН БАЙГАА БИЧИЛ ТӨСЛҮҮД

Сурч мэдсэн арга, аргачлалаа бүрэн хэрэгжүүлсэн байдлаар нь чадавх бэхжүүлэх үйл явцын үр дүнг үнэлэх нь COVID-19 тахлын үед хүрэхэд хэцүү, өндөр стандарт юм. Цар тахлын нөхцөл сайжирч, хэвийн болсны дараа доорх найман бичил төслүүд богино хугацаанд бүрэн хэрэгжих боломжтой.

Эдгээр нь:

1. Фитнесс клубт хамрагдах эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
2. Малчдын зөвлөгөөнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
3. Баяндун суманд зохион байгуулах “Хариуцлагатай уул уурхайн зөвлөгөөн”-д эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
4. Дорнод аймгийн Цагаан-Овоо суманд Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр
5. “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн туршлага судлах арга хэмжээ
6. Сум хөгжүүлэх сангийн зээл олгох хөтөлбөрт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
7. ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлд эмэгтэй бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх

8. “Нум, сум” хөтөлбөр

Зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээний (бичил төслийн)¹ нэгдсэн жагсаалтыг тайланд хавсаргав.

ТӨЛӨВЛӨӨГҮЙ ҮР ДҮН

Жишиг төслийг хэрэгжүүлэх явцад урьдчилан төлөвлөөгүй гурван эерэг үр дүн гарлаа:

- Хамт олныхоо оролцоо, идэвхи, хэрэгжүүлж буй зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээнүүдийн чанарыг үнэлж Дорнод аймгийн Засаг дарга үр дүн гарахуйц зарим бичил төслийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дэмжлэг олгов.
- Мэдлэг бататгах сургалтын үеэр оролцогчид “Уриалга” боловсруулж, орон нутгийн удирдлага, төрийн байгууллагуудад хүргүүлэв (Хавсралт)
- ЖМТ-ийн чадавх бэхжүүлэх аливаа төслийг удирдан явуулах мэдлэг, ур чадвар эзэмшсэн үндэсний 2 зөвлөх багш бэлтгэгдсэн

Сөрөг үр дүн ажиглагдаагүй.

¹ Бичил төслүүд нь:

1) Соёлын биет бус өвийн бүртгэл, түгээн дэлгэрүүлэхэд эмэгтэй өв тээгчдийн оролцоог нэмэгдүүлэх;
2) Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын арга хэмжээг дэмжих хөтөлбөр;
3) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагч эмэгтэйчүүдийг дэмжих.



СУРГАЛТЫН АГУУЛГА

Сургалтын агуулгыг жишиг төсөлд тусгайлан тохируулж боловсруулсан бөгөөд Жанет Стоцкий, Ронда Шарп, Дайан Элсон, Дебби Будлендер нарын хамтарсан “Хүйс ба төрийн бодлого” бүтээлээс санаа авсан.

5 өдрийн сургалт нь оролцогчдод үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрт дүн шинжилгээ хийх энгийн арга аргачлалыг эзэмшүүлэх зорилготой. Оролцогчдын өөрсдийнх нь тодорхойлсон бодит кэйс дээр шинээр сурсан арга, аргачлалаа алхам, алхамаар хэрэглэх боломжийг бүрдүүлсэн.

Мэдлэг бататгах сургалт нь оролцогчид зөвхөн өөрсдийн албан үүргээр хязгаарлагдахгүйгээр жендэрийн дүн шинжилгээг анхаарч үзэхийг санал болгосон. Ингэснээр сургалтад оролцогчид нийгэм болон эмэгтэйчүүдэд тулгарч буй тэгш бус байдлын эсрэг төрөөс авч буй хариу арга хэмжээг жендэрийн өнцгөөр харах чадвар эзэмшсэн.

Оролцогчдод дараах найман арга, аргачлалыг хүргэлээ. Үүнд:

1. Судалж буй бодлого, хөтөлбөр, байгууллагын цар хүрээг тодорхойлох хүснэгт
2. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдэд зарцуулж буй төсвийн зарлагыг шинжлэх хүснэгт
3. Эрэгтэй, эмэгтэй хүмүүст зарцуулж буй цалингийн зардлыг шинжлэх хүснэгт
4. Зөрүүтэй байдлын шалтгааныг тодорхойлж шинжлэх арга
5. Зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээг боловсруулах маягт
6. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, охид, хөвгүүдийн цаг зарцуулалтыг шинжлэх аргачлал буюу цаг төсөвлөлт
7. Төрийн үйлчилгээ авахад эмэгтэйчүүдэд тулгарч байгаа саад, бэрхшээлүүдийг илрүүлэх аргачлал

8. Персона аргачлал буюу мөн эмэгтэйчүүдийн ялгаатай байдлыг тооцох, саадыг илрүүлэх аргачлал

Сургалтын энэ аргачлал нь оролцогч сурснаа шууд ашиглах боломжийг олгодог. Бенжамин Блумын бүтээлч аргачлалыг сургалтанд ашигласнаар оролцогчдын оролцоог өдөөж оролцогчид нөхцөл байдлыг жижиг хэсгүүдэд задлан дүн шинжилгээ хийх, үнэ цэнээр (үр шимээр) нь төрийн үйл ажиллагааг үнэлэх цаашлаад маш богино хугацаанд тэгш бус байдлыг бууруулах зохистой хариу арга хэмжээг боловсруулахад сурсан арга техникийг ашиглахаар төлөвлөсөн.

Оролцогчид дээрх дадлага ажлаар сургалтын агуулгыг баяжуулсан. Мөн оролцогчид үндэсний зөвлөхүүдтэй хамтран, дэмжиж ажилласан.

Дадлагажуулах уулзалт (коучинг) нь оролцогч, зөвлөхүүд хоорондоо бодит байдал, мэдээллээ нээлттэй солилцсон онцлог уулзалт байлаа. Сургалтын агуулгын талаарх эргэлзээ эргэцүүлэл, бичил төслийг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийн талаар нээлттэй ярилцаж байлаа. Зарим багууд бодит байдалд тохируулж төслөө өөрчилсөн.

Коучингийн үеэр, MERIT төслийн баг оролцогчдод бичил төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж ажиллахыг зөвлөсөн.

Сургалтын бүх танилцуулга болон гарын авлага доорх вебсайтаас унших, татаж авах боломжтой <http://portal.merit.mn/en/dataset/grb-guide2020>

Сургалтад оролцогчдын сэтгэл ханамжийн судалгаа болон амжилттай хэрэгжсэн бичил төслүүд нь сургалтын агуулга оролцогчдын хэрэгцээнд нийцсэнийг харуулж байна.

СУРГАМЖ

АЛГУУР АРГАЧЛАЛ

Жендэрийн тухай ярих нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зан байдал, итгэл үнэмшилд сорилтыг бий болгож байдаг. Жендэрийн тухай яриа нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зан байдал, итгэл үнэмшилтэй нийцэхгүй байх тохиолдол бий. Хэт нэг талыг барьсан, үзэл сурталжсан яриа нь оролцогчдод дарамт учруулж сургалтаас татгалзах хандлагыг бий болгодог. Иймээс улсын төсөв, төрийн бодлого гэх мэт төвийг сахисан буюу хэн бүхний мэддэг сэдвээр сургалтаа эхэлсэн нь алгуур аргачлалын давуу тал юм.

Тодорхой бүлэгт (орон нутаг, хот, орлого, угсаатан, хүйс) хамаарах бодлогын үнэлгээ, шинжилгээнээс сургалтаа эхэлснээр болзошгүй эсэргүүцлийг бууруулдаг. Бодлого, хөтөлбөр, төслийн нөлөөлөлд хүйсээр ангилсан дүн шинжилгээ хийх нь зайлшгүй хийх ажил (дүн шинжилгээ) гэж хүлээн зөвшөөрөгддөг.

Байгууллагын үйлчилгээнээс үр шим хүртэгчдийн бүтцэд дүн шинжилгээ хийж улмаар төрийн үйлчилгээний эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд үзүүлэх ялгаатай нөлөөллийн талаар зөв ойлголттой болсны дараа нийгэм дэх жендэрийн зөрүүтэй байдалд дүн шинжилгээ хийх нь зөв алхам байсан.

Сургалтыг синхрон орчуулгатай хүргэсэн. Жендэрийн нарийн ялгаатай үг хэллэгийг зөв, тохиромжтой орчуулж чадах, чадварлаг орчуулагчийг сонгосноор сургалтын агуулгыг бүрэн дүүрэн ойлгуулах, цаашлаад оролцогчид сургалтыг сэтгэл ханамжтайгаар хүлээн авахад ихээхэн нөлөөлсөн.

ЗӨВЛӨХ, СУРГАГЧ БАГШ НАРЫН ЧАДАМЖ

Сайтар бэлтгэгдсэн, шийдвэр гаргах түвшний (нийт оролцогчдын 20%), төрийн захиргааны удирдлагын суурь мэдлэг сайтай төрийн албан хаагчид жишиг төсөлд оролцсон тул үндэсний болон ОУ-ын сургагч багш нар туршлага, үгийн сонголт, улсын төсөвлөлт, төрийн бодлогын тухай иш татах эх сурвалж, төрийн удирдлагын онолд жендэрийн дүн шинжилгээг уялдуулах зэрэгт онцгой хариуцлагатай хандах шаардлага тулгарч байлаа.

Мөн түүнчлэн, жендэрийн дүн шинжилгээ болон жендэрийн онолыг уялдуулах нь нь сорилт байсан. Жендэрийн онолыг сургалтын хоёрдугаар шатанд заах нь тохиромжтой байлаа.

БАЙНГИЙН ЭРГЭХ ХОЛБОО

Төслийн зөвлөх баг сургалтаас олж авсан зүйлээ амьдралд хэрэгжүүлэхийг дэмжиж, тусалж байсан хэдий ч оролцогчид өдөр тутмын ажилдаа сатааран сургалтын үеэр боловсруулсан зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд төдийлөн ач холбогдол өгөхгүй, хойш тавих явдал гарч байв.

Багийн гишүүдтэй байнгын эргэх холбоотой байсан нь жишиг төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. MERIT төслийн баг оролцогчидтой имэйлээр, утсаар, биечилсэн болон онлайн уулзалтаар байнга холбогдож, бичил төслийн ахицыг тодруулж, тэднийг зоригжуулж, зарим тохиолдолд төвөгтэй асуудалд хамтран шийдэл олж байсан.

Энэ нь жишиг төслийн амжилтад түлхэц үзүүлсэн.

УДИРДЛАГЫН ДЭМЖЛЭГ

Аймгийн Засаг даргын жендэрийн бодлого хэрэгжих ёстой гэсэн итгэл үнэмшил, сургалтын үйл ажиллагаатай танилцсан, удирдах албан хаагчдаа сургалтад хамрагдах талаар үүрэг, чиглэл өгсөн зэрэг нь албан хаагчид сургалтад бүрэн дүүрэн, идэвхтэй оролцож, сурсан арга техникээ хэрэгжүүлэх ёстойг гэдгийг сайтар ойлгуулсан.

Энэ нь сургалтыг удирдан явуулахад мөн томоохон дэмжлэг болсон.

АЛБАН ХААГЧДЫН МАНЛАЙЛАЛ

Дорнод аймгийн ЗДТГ-ын Нийгмийн Бодлогын хэлтсийн дарга жишиг төслийн үйл ажиллагаанд манлайлан оролцож, дэмжиж ажилласан. Тэрээр MERIT төслийн хамт олон болон 2020 оны 7, 8-р саруудад зохион байгуулсан 5 өдрийн гурван удаагийн сургалтад оролцогчдыг чиглүүлж оролцсон.

Энэ нь сургалтыг хүргэхэд мөн томоохон дэмжлэг болсон.

ОРЧУУЛГЫН ЧАНАР

Жишиг төслийг монгол хэл мэдэхгүй, гадаад зөвлөх удирдан явуулсан тул оролцогчид сургалтын агуулгыг бүрэн ойлгоход орчуулгын чанар маш чухал үүрэг гүйцэтгэсэн. Зөвхөн үг, өгүүлбэрийг эх хэл рүүгээ хөрвүүлэх төдийгүй жишиг төслийн явцад чухал үүрэгтэй зарим шинэ нэр томъёоны утга санааг сайн илтгэх үг хэллэг, хэлцийг тохируулан хэрэглэх шаардлагатай байлаа.



ТӨСЛИЙН БАГТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

Жишиг төслийн хүрээнд бий болсон үйл явцыг MERIT төсөл хэрэгждэг бусад гурван аймаг болох Төв, Дундговь, Сүхбаатар аймагт хэрэгжүүлэх нь зүйтэй. Гэхдээ урьдчилан, аймгийн Засаг даргын хүсэл эрмэлзлэл, манлайлагч төрийн албан хаагч байгаа эсэх, цаашлаад сургалтыг хамтран удирдан явуулах монгол багш, зөвлөхүүдийн боломж, санхүүжилт шийдэгдсэн эсэхийг харгалзан үзэх нь чухал юм. Эдгээр зүйлс тодорхой болж, холбогдох удирдах албан тушаалтнуудтай тохиролцсоны үндсэн дээр нэг жилийн хугацаатай уг үйл явцыг эхлүүлэх боломжтой.

MERIT төслийн санхүүгийн дэмжлэггүйгээр төслийн хамтрагч бус аль нэг аймагт аргачлалыг туршиж болох юм. Тухайлбал, зарим уулзалтад оролцуулах, гарын авлагыг хэрэглэх, сургамжийг хуваалцах зэргээр дөрөвдөгч аймгийг урьж оролцуулж болох юм. Мэдээж, аймгийн Засаг даргын дэмжлэг, манлайлагч төрийн албан хаагч байгаа эсэх нь урьдач нөхцөл болно.

Үйл явцыг нэвтрүүлэх, аргачлалыг хэрэгжүүлэхийн тулд аль нэг яамыг оролцуулах нь зүйтэй. Түүнчлэн зарим уулзалтад урьж оролцуулах, гарын авлагыг хэрэглэх, сургамжийг хуваалцах зэргээр төрийн захиргааны төв байгууллага болох яамыг оролцуулахад маш их хүчин чармайлт хэрэгтэй. Сайдын дэмжлэг, манлайлагч

төрийн албан хаагч байгаа эсэх нь мөн урьдач нөхцөл болно.

Албан хаагчдын шилжилт, хөдөлгөөнийг анхаарч үзэх нь зүйтэй. Цөөн албан хаагчтай байгууллагын хувьд, шилжилт хөдөлгөөн нь зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээний хэрэгжилт, байгууллага дотор мэдлэг, ур чадварыг түгээх явдалд ихээхэн нөлөөлдөг.

Үйл явцыг дараах байдлаар түгээн дэлгэрүүлэх боломжтой.

- Төрийн албан хаагчид зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээг боловсруулахад чиглэсэн 5 өдрийн жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн сургалт
- 5 өдрийн сургалтын үеэр боловсруулсан зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх 2 цагийн дадлагажуулалт (коучинг).
- Нийгэм, байгууллага дах жендэрийн дүн шинжилгээ хийх мэдлэгээ тэлэх, бататгах хоёр хагас өдрийн мэдлэг бататгах сургалт.
- Харилцан бие, биенээсээ урам авах, туршлага хуваалцах, суралцах зорилгоор бүх багууд хамт уулзах үйл ажиллагааг хамгийн багадаа нэг удаа зохион байгуулах.



СУРГАМЖ:

- Улсын төсөв, төрийн бодлого гэх мэт төвийг сахисан буюу хэн бүхний мэддэг сэдвээр сургалтыг эхлүүлэх нь зүйтэй. Тодорхой бүлэгт (орон нутаг, хот, орлого, угсаатан, хүйс) хамаарах бодлогын үнэлгээ, шинжилгээнээс сургалтаа эхэлснээр болзошгүй эсэргүүцэх хандлагыг бууруулна. Зайлшгүй хийх ажил гэж хүлээн зөвшөөрөгдөхүйц бодлого, хөтөлбөр, төслийн нөлөөлөлд хүйсээр ангилсан дүн шинжилгээ хийх.
- Улсын төсөв, төрийн бодлого, төрийн удирдлагын онолд жендэрийн дүн

шинжилгээг уялдуулах талаар ярих чадвартай, хариуцлагатай үндэсний болон олон улсын зөвлөхийг сонгох.

- 5 өдрийн сургалтын үеэр бүрдсэн багуудтай байнгын эргэх холбоотой байхаар төлөвлөх. Тэднийг дэмжиж урамшуулах, шаардлагатай үед асуудлаа шийдэхэд нь туслах.

Сурсан мэдснээ амьдралд хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ үндэсний баг, олон улсын туршлагатай эх сурвалжийг ашиглан дадлагажуулж (коучинг) нь зүйтэй.

БОДЛОГО ТОДОРХОЙЛОГЧ НАРТ ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

МУ-ын хэмжээнд бүх захиргааны байгууллагад хялбар нэвтрүүлэх боломжтой жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн алхамчилсан үйл явцыг тодорхойлох. Тухайлбал, төрийн албан хаагчид өөрсдийн хариуцан хэрэгжүүлж буй хөтөлбөр, дотоод дүрэм журам, бодлого, нийгмийн орчинд дүн шинжилгээ хийж жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах аргачлалтай болно гэсэн үг.

Төрөөс баримтлах жендэрийн эрх тэгш байдлын бодлогыг өдөр тутмын чиг үүрэгт хэвшүүлэх чиглэлээр орон нутгийн болон салбарын тус бүрийн албан хаагчдыг чадавхжуулах. Тухайлбал,

- Төрийн албан хаагчдын одоогийн чиг үүрэгт нийцүүлэн тэднийг өдөр тутмын ажлаа жендэрийн өнцгөөс харахад туслах хүртээмжтэй, хялбаршуулсан жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн гарын авлага номыг ашиглах.
- Энэхүү гарын авлагатай хосолсон цахим сургалт нь төрийн албан хаагчдын жендэрийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэх, өөрчлөлтийг хэрэгжүүлэх, цаашлаад санаачлагаараа манлайлан ажиллахад нь тусална.
- Стратегийн ач холбогдол бүхий бүс нутаг болон салбарт томоохон өөрчлөлтийг

бий болгохын тулд танхимын цуврал сургалтыг¹ зохион байгуулах.

- Удирдлагын Академийн төрийн албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөрт жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн хичээл нэмж оруулах.

МУ-ын Сангийн Яаманд жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг хариуцах нэгж, хэлтсийг байгуулах. Уг нэгж нь гарын авлага боловсруулах, түгээх; цахим сургалтад хамрагдаж байгаа эсэхэд хяналт тавих; танхимын сургалт зохион байгуулах, коучинг хийх; цахимаар дэмжлэг үзүүлэх; асуудлыг цаг тухайд нь тодруулж, шийдвэрлэж ажиллах.

Үнэлгээг дэмжих, системтэйгээр суралцахыг урамшуулах, мэдлэгийг тэлэх зорилгоор жил бүр үндэсний хэмжээний уулзалт зохион байгуулах.

- Төв болон орон нутгийн байгууллагууд, стратегийн ач холбогдол бүхий салбар, нэн чухал төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг хамруулан бий болгосон хүчин чармайлт, тулгамдаж буй асуудал, хүрсэн үр дүнгээ хэлэлцэх хоёр өдрийн арга хэмжээ зохион байгуулах.

¹ Цуврал сургалт нь дараах бүтэцтэй байж болно. Үүнд:

- Төрийн албан хаагчид зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээг боловсруулахад чиглэсэн 5 өдрийн жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн сургалт
- 5 өдрийн сургалтын үеэр боловсруулсан зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх 2 цагийн дадлагажуулалт (коучинг).
- Нийгэм, байгууллагад жендэрийн дүн шинжилгээг хийх талаарх хоёр хагас өдрийн мэдлэг бататгах сургалт.
- Харилцан бие, биенээсээ урам авах, туршлага хуваалцах, суралцах зорилго бүхий багуудын мэдээлэл солилцох арга хэмжээг хамгийн багадаа нэг удаа зохион байгуулах.

- Эдгээр үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх. Уг стратеги нь нийт хүн амын ойлголтыг нэмэгдүүлснээр соёл, нийгэм дэх эерэг өөрчлөлтийг бий болгоход хувь нэмрээ оруулахын зэрэгцээ шийдвэр гаргагчид албан хаагчдаа дэмжих, уг арга хэмжээнд оролцуулах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг болно.
- Хүчин чармайлтыг нэмэгдүүлэхийн тулд тусгайлсан урамшууллын систем бий болгож болно.

Жендерийн үндэсний хороо, Иргэний нийгмийн байгууллагуудын (ТББ, Их сургууль) Улсын төсөвт жендерийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр хяналт-шинжилгээ хийх чадавхыг бэхжүүлэх. Эдгээр байгууллага нь Төсвийн тухай хууль нь жендерийн эрх тэгш байдлыг нэмэгдүүлж байна уу эсвэл бууруулж байна уу гэдгийг нягталдаг байх.

Жендерийн тэгш байдлыг хангах буюу жендерийн мэдрэмжтэй улсын төсөв боловсруулж, батлахад дэмжлэг үзүүлэх зорилгоор жендерийн тайланг Төсвийн тухай хуулийн хавсралт болгох.

ХАВСРАЛТУУД

Зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээний жагсаалт

Баг	Зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ
1 бүлэг 1-р баг	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын арга хэмжээг дэмжих хөтөлбөр
1 бүлэг 2-р баг	Малчдын зөвлөгөөнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
1 бүлэг 3-р баг	Төрийн албан хаагчдын мэргэшүүлэх сургалт
1 бүлэг 4-р баг	"Нум, сум" хөтөлбөр
1 бүлэг 5-р баг	"Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах" хөтөлбөр
1 бүлэг 6-р баг	Соёлын биет бус өвийн бүртгэл, түгээн дэлгэрүүлэхэд эмэгтэй өв тээгчдийн оролцоог нэмэгдүүлэх
1 бүлэг 7-р баг	Дорнод аймгийн Цагаан-Овоо суманд Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр
2 бүлэг 1-р баг	"Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд Багийн удирдах түвшний эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
2 бүлэг 2-р баг	Нийтийг хамарсан ажилд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
2 бүлэг 3-р баг	Хяналт, үнэлгээний олон нийтийн зөвлөлд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
2 бүлэг 4-р баг	Фитнесс клубт хамрагдах эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
2 бүлэг 5-р баг	Хүүхдийн хоол" хөтөлбөрийн тендер шалгаруулалтад эмэгтэй бизнес эрхлэгчдийн оролцоог дэмжих
2 бүлэг 6-р баг	Малжуулах хөтөлбөрт эмэгтэй малчдын оролцоог нэмэгдүүлэх
2 бүлэг 7-р баг	Залуучуудын гарааны бизнесийг дэмжих СТАРТ АП хөтөлбөрт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
2 бүлэг 8-р баг	"Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн туршлага судлах арга хэмжээ
2 бүлэг 9-р баг	ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлд эмэгтэй бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх
3 бүлэг 1-р баг	Төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэгч компанийн хүний нөөцийн бүрдүүлэлтэд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх
3 бүлэг 2-р баг	Сум хөгжүүлэх сангийн зээл олгох хөтөлбөрт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
3 бүлэг 3-р баг	"Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог дэмжин ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг хөгжүүлэх" арга хэмжээг сайжруулах
3 бүлэг 4-р баг	Хог хаягдлын менежментийг сайжруулах" хөтөлбөр Цэвэр цэмцгэр Чойбалсан хот төсөл
3 бүлэг 5-р баг	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагч эмэгтэйчүүдийг дэмжих
3 бүлэг 6-р баг	Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
3 бүлэг 7-р баг	Залуу малчин хөтөлбөрийн малжуулах төслийн зээлд эмэгтэй малчдыг хамруулах
3 бүлэг 8-р баг	Баяндун суманд зохион байгуулах "Хариуцлагатай уул уурхайн зөвлөгөөн"-д эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
3 бүлэг 9-р баг	Буйр нуур орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажилд эмэгтэйчүүд орлого олох боломжийг нэмэгдүүлэх
3 бүлэг 10-р баг	"Старт-АП"бизнесийг дэмжих туршлага судлах арга хэмжээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
Хувь хүн	Номын сан



УРИАЛГА

“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” сургалтад оролцогчдоос нийгэм дэх жендэрийн зөрүүтэй байдлыг арилгахад оруулах хувь нэмрээ нэмэгдүүлэх талаар орон нутгийн удирдлага, байгууллагуудад хандаж гаргасан УРИАЛГА

2021 оны 8 дугаар сарын 25-ны өдөр

Чойбалсан хот

Монголчууд бид амьдралын хэв маяг, зан заншлаас үүдэлтэй өвөрмөц соёл бүхий ард түмэн тул нийгэм дэх жендэрийн зөрүүтэй байдлыг арилгаж, жендэрийн тэгш эрхийг хангах чиглэлээр орон нутгийн удирдлага, байгууллага, төрийн албан хаагчид бүх түвшинд нэгдмэл ойлголттойгоор хамтран ажиллах зорилгоор дараах уриалгыг гаргаж байна.

Төрийн албан хаагчид:

Төрийн албан хаагч бүр өдөр тутмын үйл ажиллагаандаа болон бодлогын баримт бичиг, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үр нөлөөг нь үнэлэхдээ жендерийн мэдрэмжтэй хандлага, арга зүйтэй ажиллацгаая.

Иргэддээ үйлчлэхдээ төрийн албан хаагч бүр үзэл бодол, зан суртахуун, үг, үйлдлээрээ жендерийн зөрүүтэй байдлыг гаргахгүй байхад цаг ямагт анхаарч ажиллаж хэвшигчээ.

Төрийн болон орон нутгийн байгууллагууд:

Байгууллагууд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ өөрийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэл, чиг үүргээс үл хамааран хүн ам зүйн нас, хүйс, бүлэг хүмүүсийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрхэд суурилсан жендерийн мэдрэмжтэй бодлого, үйл ажиллагаа явуулж, дүн шинжилгээ хийж ажиллацгаая.

Төрийн болон орон нутгийн байгууллага бүр хүйсээр ангилсан жендэрийн судалгаанд тулгуурлан үйл ажиллагаагаа жендерийн мэдрэмжтэйгээр төлөвлөж, жендерийн талаарх хэвшмэл ойлголтыг арилгах чиглэлээр соён гэгээрүүлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг нь хэлэлцэн, тайлагнаж хэвшье.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

Аймаг, сумын бодлого тодорхойлогчид, шийдвэр гаргагчид болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх замаар хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах ажлыг бодлогын түвшинд удирдлага, арга зүй, нөөц, боломжоор ханган ажиллая.

Нутгийн удирдлагаас батлан гаргаж буй бодлого, шийдвэр, өргөн баригдсан төсвийн төсөлд жендерийн тэгш байдлыг хангасан эсэхийг харгалзан үзэж, төсвийн удирдамжид жендерийн асуудлыг заавал тусгах замаар төсвийн бодлогыг тодорхойлж, төлөвлөх, хэлэлцэн батлах, хяналт, аудит хийх, үр нөлөөг нь үнэлэхдээ жендэрийн мэдрэмжтэй хандацгаая.

Иргэний нийгэм, ТББ-уудад:

Төрийн бодлого, үйлчилгээний үр шимийг хүртэгчид буюу иргэд, төрийн удирдах болон улс төрийн албан тушаалтнуудын жендерийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн нөлөөллийн ажлыг өргөжүүлж, үр дүнг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулцгаая.

Төрийн бодлого, үйлчилгээнд оролцоонд тулгуурласан, хөндлөнгийн хяналт шинжилгээ, мониторинг, аудитыг жендэрийн нөхцөл байдлын судалгаанд үндэслэн жендэрийн мэдрэмжтэй хийдэг болцгооё.

Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд:

Нийгэм дэх жендэрийн зөрүүтэй байдал, жендерийн хэвшмэл ойлголтын эсрэг хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлье.

Багийн бүрэлдэхүүний хүйсээр ангилсан мэдээлэл

#	Баг	Хүйс Эм Эр		Зөрүүтэй байдлыг арилгах хариу арга хэмжээ
1	1 бүлэг 1-р баг	2	1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын арга хэмжээг дэмжих хөтөлбөр
2	1 бүлэг 2-р баг	2	1	Малчдын зөвлөгөөнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
3	1 бүлэг 3-р баг	2	1	Төрийн албан хаагчдын мэргэшүүлэх сургалт
4	1 бүлэг 4-р баг	2	1	"Нум, сум" хөтөлбөр
5	1 бүлэг 5-р баг	2	1	"Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах" хөтөлбөр
6	1 бүлэг 6-р баг	2	1	Соёлын биет бус өвийн бүртгэл, түгээн дэлгэрүүлэхэд эмэгтэй өв тээгчдийн оролцоог нэмэгдүүлэх
7	1 бүлэг 7-р баг	2	2	Дорнод аймгийн Цагаан-Овоо суманд Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр
8	2 бүлэг 1-р баг	2	1	"Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд Багийн удирдах түвшний эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
9	2 бүлэг 2-р баг	2	1	Нийтийг хамарсан ажилд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
10	2 бүлэг 3-р баг	2	1	Хяналт, үнэлгээний олон нийтийн зөвлөлд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
11	2 бүлэг 4-р баг	2	1	Фитнесс клубт хамрагдах эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
12	2 бүлэг 5-р баг	2	1	Хүүхдийн хоол" хөтөлбөрийн тендер шалгаруулалтад эмэгтэй бизнес эрхлэгчдийн оролцоог дэмжих
13	2 бүлэг 6-р баг	2	1	Малжуулах хөтөлбөрт эмэгтэй малчдын оролцоог нэмэгдүүлэх
14	2 бүлэг 7-р баг	3		Залуучуудын гарааны бизнесийг дэмжих СТАРТ АП хөтөлбөрт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
15	2 бүлэг 8-р баг	3		"Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийн туршлага судлах арга хэмжээ
16	2 бүлэг 9-р баг	2		ЖДҮ-ийг дэмжих хөнгөлөлттэй зээлд эмэгтэй бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх
17	3 бүлэг 1-р баг	3		Төсвийн хөрөнгөөр ажил гүйцэтгэгч компанийн хүний нөөцийн бүрдүүлэлтэд эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх
18	3 бүлэг 2-р баг	2	1	Сум хөгжүүлэх сангийн зээл олгох хөтөлбөрт эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
19	3 бүлэг 3-р баг	3		"Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш оролцоог дэмжин ойн нөхөрлөлийн үйл ажиллагааг хөгжүүлэх" арга хэмжээг сайжруулах
20	3 бүлэг 4-р баг	2	1	Хог хаягдлын менежментийг сайжруулах" хөтөлбөр Цэвэр цэмцгэр Чойбалсан хот төсөл
21	3 бүлэг 5-р баг	2	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагч эмэгтэйчүүдийг дэмжих
22	3 бүлэг 6-р баг	3		Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг сургалтад хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
23	3 бүлэг 7-р баг	4		Залуу малчин хөтөлбөрийн малжуулах төслийн зээлд эмэгтэй малчдыг хамруулах
24	3 бүлэг 8-р баг	3		Баяндун суманд зохион байгуулах "Хариуцлагатай уул уурхайн зөвлөгөөн"-д эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
25	3 бүлэг 9-р баг	3	1	Буйр нуур орчмын хог хаягдлыг цэвэрлэх ажилд эмэгтэйчүүд орлого олох боломжийг нэмэгдүүлэх
26	3 бүлэг 10-р баг	2	1	"Старт-Ап"бизнесийг дэмжих туршлага судлах арга хэмжээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх
Нийт		61	19	

ЖМТ жишиг төслийн үйл ажиллагааны зургийн цомгоос:



INTELLIGENCE PUBLIQUE

Олон Улсын зөвлөх Мишель Филионий эзэмшдэг Intelligence Publique компани нь Африк, Ази, Америк тивд техникийн туслалцаа, зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан арвин туршлагатай юм. Жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх хүрээнд хэрэгжүүлсэн ажлын туршлагаас дурдвал:

- Хөгжиж буй улс орнуудын төрийн албан хаагчдад жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн чиглэлээр чадавхжуулах сургалтыг 2007 оноос хойш хийж байгаа.
- Канад, Перу улсын хамтарсан ProGobernabilidad төслийн хүрээнд Перу улсын орон нутгийн захиргааны байгууллагад “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт”-ийг 2012-2018 онд хэрэгжүүлсэн.
- Канад Улсын Гадаад хэргийн яамны санхүүжилттэй MERIT төслийн хүрээнд Монгол Улсын орон нутгийн захиргааны байгууллагад “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” сэдвээр чадавх бэхжүүлэх сургалтыг 2019 онд хүргэсэн.
- Plan Sɯnɯgal Ймергент Канад-Сенегалын техник туслалцааны төслийн хүрээнд 2020 онд Сенегалын Засгийн газарт зориулан “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” сэдвээр чадавх бэхжүүлэх сургалтын материалыг боловсруулсан.
- Канад улсын Хотын захиргааны холбоотой хамтран Африк (Хойд ба Баруун Африкийн орнууд)-ийн орнуудын хотын захиргааны байгууллагуудыг “Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” чиглэлээр чадавхжуулах ажлыг 2021 онд хүргэсэн.
- Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн чиглэлээр 2 гарын авлага испани, англи (монгол орчуулга) хэлээр боловсруулсан.

Зөвлөх Филион нь 32 улсын 65 засгийн газартай хамтран ажилласан туршлагатай. Түүний Intelligence Publique компани нь Амазоны сав газарт Америкийн Хөгжлийн Банкны 300 сая долларын санхүүжилт бүхий томоохон төсөлд цахим болон биечлэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг эхлүүлээд байна.